

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.24 дэх заалт, 8.5 дахь хэсэг, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 21 дүгээр тогтоол, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.14, 2.3.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт зорилтот бүлгийн хүн амыг хамруулах үйл ажиллагааг зохион байгуулах журам”-ыг нэгдүгээр, “Нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт зорилтот бүлгийн хүн амыг хамруулах товлал, давтамж”-ийг хоёрдугаар, “Нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн зураглал”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрт илрүүлгийн зардлыг санхүүжүүлэхтэй холбоотой журмыг шинэчлэн боловсруулан, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөр батлуулахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (Ц.Батбаатар)-т даалгасугай.

3. Эрт илрүүлгийг зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангаж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгийн ач холбогдлыг сурталчлахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Л.Баттөр), эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааны зохицуулалтын талаар эрүүл мэндийн байгууллага, даатгуулагчдад зориулсан зөвлөгөө, мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (Ц.Батбаатар)-т тус тус даалгасугай.

4. Эрт илрүүлгийн цахим бүртгэлийн нэгдсэн мэдээний сан байгуулах, хадгалах, баяжуулах, ашиглах, эрүүл мэндийн байгууллагууд мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлж, үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (М.Одгэрэл), хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, бодлого, зохицуулалтаар хангаж ажиллахыг Бодлого төлөвлөлтийн газрын Эрүүл мэндийн инноваци, технологи, цахим хөгжлийн хэлтэс (Б.Түмэннаст), эрүүл мэндийн даатгалын мэдээллийн сангийн өгөгдөл солилцох ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (Ц.Батбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

5. Эрт илрүүлэгт шаардагдах лабораторийн урвалж бодис, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийн хангамжийн асуудлаар эрүүл мэндийн байгууллагуудыг мэдээллээр хангаж ажиллахыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар (П.Алтанцэцэг)-т үүрэг болгосугай.

6. Эрт илрүүлэг хийхэд шаардлагатай хүний нөөцийг сургах, эрүүл мэндийн ажилтанг чадавхжуулах сургалт зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв

(М.Одгэрэл), хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, бодлого, зохицуулалтаар хангаж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар (Б.Туяа)-т тус тус даалгасугай.

7. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн тайлан, мэдээнд дүн шинжилгээ хийж, нэгтгэхийг Эрүүл мэндийн хөгжлийн төв (М.Одгэрэл), Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (Ж.Отгонбаатар), Хавдар судлалын үндэсний төв (Ц.Батболд), эрт илрүүлгийн тайлан, дүн мэдээнд үндэслэн мэдээлэл, сургалт сурталчилгааг үндэсний хэмжээнд зохион байгуулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Л.Баттөр), эрт илрүүлгийн өгөгдөл, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, шийдвэр гаргагчдыг нотолгоонд суурилсан мэдээлэл, зөвлөмжөөр хангахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газар (М.Наранпүрэв), үйл ажиллагааны хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, бодлого, зохицуулалтаар хангаж ажиллах, үр дүнг хагас жил тутам сайдын зөвлөлд танилцуулахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газар (Б.Цэцэгсайхан)-т тус тус даалгасугай.

8. Эрт илрүүлэгт хүн амыг хамруулах үйл ажиллагааг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт, удирдлага зохицуулалтаар хангахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газар (Б.Цэцэгсайхан), эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Б.Янжмаа)-т тус тус үүрэг болгосугай.

9. Эрт илрүүлгээр илрүүлсэн өвчлөлийн сэжигтэй тохиолдлыг хяналтад авч, эргэх холбоо тогтоон ажиллахыг эрүүл мэндийн байгууллагуудад, нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газар (М.Наранпүрэв), эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулахад шаардагдах санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгуулан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газар (М.Мөнхцэцэг), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газар (Б.Цэцэгсайхан)-т тус тус үүрэг болгосугай.

10. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2025 оны “Журам батлах тухай” А/04 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД

Ж.ЧИНБҮРЭН

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын хэмжээнд төрийн өмчийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаар дамжуулан 2022 оны 05 сарын 01-ний өдрөөс эхлүүлэн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог хийж эхэлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 111 дүгээр тогтоол, 03 дугаар сарын 10, 11 дүгээр тэмдэглэл, 12 дугаар сарын 51 дүгээр тэмдэглэлээр холбогдох яамдад тус тус эрт илрүүлгийг эрчимжүүлэн ажиллах чиглэл өгсөн.

Ингэснээр Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл (ЭМДҮЗ)-ийн 2022 оны “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай” 06 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл (ЭМДҮЗ)-ийн 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 10 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан.

Мөн Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дугаар тушаалаар “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах журам”-ыг шинэчлэн, боловсруулж 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/379 дүгээр “Журам батлах тухай” тушаалаар тус тус батлуулан эрт илрүүлэг, үзлэг шинжилгээ зохион байгуулагдаж байсан.

Ингээд Эрүүл мэндийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар “Нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт зорилтот бүлгийн хүн амыг хамруулах үйл ажиллагааг зохион байгуулах журам, үзлэгийн товлал, давтамж, зураглал”-ыг шинэчлэн баталсан.

2024 оны 09 дугаар сарын 18-ны байдлаар улсын хэмжээнд хамрагдвал зохих хүн амын 51.1 хувь буюу 1,727,428 иргэни бүрийг хамруулаад байна. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношлогоонд хамрагдсан нийт хүний 760,807 буюу 44.0 хувь нь 0-17 насны хүүхэд, 966,621 буюу 56.0 хувь нь 18-аас дээш насныхан байна.

Нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт зорилтот бүлгийн хүн амыг хамруулах үйл ажиллагааг зохион байгуулах журмын мэдээллийн санд дүн шинжилгээ хийж, эрт илрүүлгийн багц, товлолыг шинэчлэн тогтоох, цаашдын чиг хандлагыг тодорхойлох ажлын хүрээнд тус эрт илрүүлэг, үзлэгийг 2025 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс түр хугацаагаар зогсоогоод байгаа билээ.

Иймд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгооны багц, товлолыг шинэчлэн, боловсруулах шаардлага, хэрэгцээ үүссэн.

**НАС, ХҮЙС, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРСДЭЛД СУУРИЛСАН УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ҮЗЛЭГТ ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ХҮН АМЫГ
ХАМРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл, зорилго

1.1. Эрт илрүүлэг гэдэг нь нь зорилтот бүлгийн хүн амыг нэгдсэн аргаар үзлэг эсвэл шинжилгээнд хамруулж, тэднээс тодорхой өвчин, эмгэгийн эрсдэлтэй хүнийг олж илрүүлэн, нарийвчилсан оношилгоо, үнэлгээ, шинжилгээ хийж баталгаажуулснаар шаардлагатай тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэхэд чиглэсэн арга юм.

1.2. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг, оношилгоо, шинжилгээ (цаашид эрт илрүүлэг гэх) нь хүний амь нас, амьдралын чанарт ноцтой хохирол учруулах, хөгжлийн бэрхшээлд хүргэж болзошгүй халдварт болон халдварт бус өвчнийг эрт үед илрүүлж, үр дүнтэй эмчилж, ирээдүйд учирч болзошгүй хүндрэл, нас баралт, санхүүгийн дарамтаас сэргийлэх зорилготой болно.

1.3. Энэхүү журам нь өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагууд зорилтот бүлгийн хүн амд эрт илрүүлгийг товлосон хугацаанд хийх үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.4. Эрт илрүүлгийн хүрээнд анхдагч болон завсрын эрсдэлт хүчин зүйлийг үнэлэх, эмнэл зүйн үзлэг хийх, багажийн болон лабораторийн шинжилгээг гүйцэтгэж, эмнэл зүйн дүгнэлт өгөх, зөвлөгөө мэдээллээр хангах, шаардлагатай тохиолдолд лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад оношийг тодруулахаар илгээх, хянах цогц үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1.5. Энэхүү журмаар зохицуулагдаж буй эрт илрүүлэг нь төлбөртэй тусламж, үйлчилгээнд хамаарахгүй.

1.6. Эрт илрүүлгийг зорилтот бүлгээс хамаарч өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, амаржих газар, Аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Нийгмийн эрүүл мэндийн төв, Эрүүл мэндийг дэмжих төв, тусгай зөвшөөрөл бүхий өмчийн бүх хэлбэрийн эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагад хийнэ.

1.7. Алслагдсан болон газар зүйн саад бэрхшээлтэй сум, баг, хороонд амьдардаг, хөгжлийн бэрхшээлтэй болон бусад шалтгаанаар эрүүл мэндийн байгууллагад хандах боломжгүй иргэдэд явуулын хэлбэрээр эрт илрүүлгийг зохион байгуулна.

1.8. Эрүүл мэндийн байгууллага нь үйлүүлэгчдэд эрт илрүүлгийн багцад хамаарах тусламж, үйлчилгээг үзүүлж эхэлсэн болон дууссан хугацааг эрүүл мэндийн даатгалын цахим системд холбосон хурууны хээ уншигч төхөөрөмж эсвэл иргэний регистрийн дугаараар бүртгэж, баталгаажуулна.

Хоёр. Ургийн гажгийн эрт илрүүлгийн зохион байгуулалт

2.1. Ургийн гажгийн эрт илрүүлгийг жирэмсний хяналтын товллолт хугацаанд эмэгтэй бүрд журам, зааврын дагуу төрийн болон хувийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад эх барих, эмэгтэйчүүдийн эмч хийнэ.

2.2. Ургийн эрт илрүүлгийг гурван үе шаттай зохион байгуулах ба нэгдүгээр үе шатанд жирэмсэн эмэгтэй бүрийг эхний гурван сарын нийлмэл илрүүлэг шинжилгээнд хамруулна. Хоёр болон гуравдугаар үе шатны шинжилгээг заалтаар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт зохион байгуулна.

2.3. Ургийн эрт илрүүлгийг хийх эмнэлгийн мэргэжилтэн нь чадавхжуулах сургалтад хамрагдсан байна.

2.4. Ургийн эрт илрүүлгийг эрүүл мэндийн байгууллагаас зохион байгуулах:

2.4.1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь жирэмсэн эмэгтэйг тээлтийн 9 долоо хоногийн дотор жирэмсний хяналтад хамруулж, товлолын дагуу эхний үзлэгийг хийж, ургийн илрүүлэг шинжилгээ (эхний гурван сарын нийлмэл илрүүлэг)-ний талаар зөвлөгөө өгч, шинжилгээнд илгээнэ;

2.4.2. Жирэмсний хяналтын тусламж, үйлчилгээ үзүүлдэг чадамж бүхий (хүний нөөц, тоног төхөөрөмж, программ хангамж) төрийн болон хувийн өмчийн эрүүл мэндийн байгууллага нь жирэмсэн эмэгтэйд эхний гурван сарын нийлмэл илрүүлэг шинжилгээг хийж, эрсдэлийг тооцно;

2.4.3. Эхний гурван сарын нийлмэл илрүүлэг шинжилгээгээр эрсдэл бага бол жирэмсний хяналтыг товлолын дагуу үргэлжлүүлэх ба эрсдэл өндөр тохиолдолд дараагийн шатлалд илгээнэ;

2.4.4. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг эхний гурван сарын нийлмэл илрүүлэг шинжилгээгээр эрсдэл өндөр гарсан жирэмсэн эмэгтэйд НИПТ шинжилгээг хийх ба эрсдэл дахин өндөр гарсан тохиолдолд онош батлах зорилгоор ургийн кариотипийг шинжилнэ

2.4.5. Ургийн илрүүлэг шинжилгээг зохион байгуулдаг бүх шатлалын төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага нь батлагдсан маягтын дагуу өдөр бүр нэгтгэн, долоо хоног бүрийн Мягмар гараг бүр Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны албаны “Ургийн гажгийн эрт илрүүлгийн тандалтын тогтолцоо”-нд утсаар болон цахимаар мэдээлнэ. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны алба нь мэдээллийг нэгтгэж, нэгдсэн дүнг сар бүр Эрүүл мэндийн хөгжлийн төвд мэдээлнэ.

2.4.6. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны алба нь ургийн гажгийн эрт илрүүлгийн тандалтын тогтолцооны мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хариу арга хэмжээ төлөвлөхөд бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад дэмжлэг үзүүлж ажиллана.

2.4.7. Мэдээллийн үнэн зөв, хугацаанд мэдээлсэн байдалд холбогдох тасгийн эрхлэгч, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын алба, эмчилгээ эрхэлсэн дэд захирал нар өдөр бүр хяналт тавьж ажиллана.

Гурав. Нярайн эрт илрүүлгийн зохион байгуулалт

3.1. Нярайн эрт илрүүлгийг (скрининг) шинэ төрсөн нярай бүрд товлөгдсон хугацаанд цогцоор нь (зүрхний төрөлхийн гажгийн пульсоксиметрийн эрт илрүүлэг, сонсголын эрт илрүүлэг, түнхний дутуу хөгжлийн хэт авиан эрт илрүүлэг, бодисын

солилцооны эрт илрүүлэг, нүдний угийн улаан рефлексийн эрт илрүүлэг) төрөх үйл ажиллагаа эрхэлдэг, эрт илрүүлгийн чадамж бүхий (хүний нөөц, тоног төхөөрөмж, программ хангамж) улсын ба хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын төрсний дараах тасагт гүйцэтгэнэ.

3.2. Нярайн эрт илрүүлгийг эмнэлгийн мэргэжилтэн чадавхжуулах стандарт сургалтад хамрагдсан, зөвшөөрөл бүхий эмч, эрүүл мэндийн ажилтан батлагдсан эмнэл зүйн зааврын дагуу гүйцэтгэнэ.

3.3. Нярай биеийн байдал хүнд, эрчимт эмчилгээнд эмчлүүлж байгаа тохиолдолд цогц эрт илрүүлгийг товлөгдсөн хугацаанаас түр хойшлуулж, бүрэн эдгэрч, эмнэлгээс гарахаас өмнө хамруулна.

3.4. Нярайн эрт илрүүлгийн шинжилгээнд өөрчлөлт илэрсэн тохиолдлын менежментийг эрт илрүүлгийн төрлөөс хамаарч, батлагдсан эмнэл зүйн заавар, алгоритмын дагуу ялгаатай гүйцэтгэнэ.

3.5. Нярайн эрт илрүүлгийн төрлөөс хамаарч стандарт сургалтад хамрагдсан, зөвшөөрөл бүхий эмч, эрүүл мэндийн ажилтан эрт илрүүлгийн талаар олон нийтэд мэдээлэл, зөвлөгөө өгнө.

3.6. Нярайн эрт илрүүлгийг эрүүл мэндийн байгууллагаас зохион байгуулах:

3.6.1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь жирэмсэн эмэгтэйд нярайн эрт илрүүлгийн өмнөх ба дараах стандарт мэдээлэл, зөвлөгөөг өгөх ба эмгэг илэрсэн тохиолдол бүрийн эрт илрүүлгийн төрлөөс хамаарсан давтан хяналтын үзлэгт товлолын дагуу хамрагдсан эсэх, эмчилгээний зааврыг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавьж, эргэх холбоотой ажиллана;

3.6.2. Төрөх үйл ажиллагаа эрхэлдэг эрүүл мэндийн байгууллагад нярайн түүх нээсэн нярай бүрийг (гэрийн төрөлтийг оролцуулан) нярайн цогц эрт илрүүлэгт хамруулна;

3.6.3. Төрөх үйл ажиллагаа эрхэлдэг эрүүл мэндийн байгууллагад нярайн эрт илрүүлгийн онцлогоос хамаарч батлагдсан эмнэл зүйн заавар, алгоритмын дагуу оношийн чанарын баталгаажуулалтыг хийж, скринингийн төрлөөс хамаарч шаардлагатай мэдээлэл, хэт авиан зураг зэргийг цахим тогтолцоонд байршуулна.

3.6.4. Төрөх үйл ажиллагаа эрхэлдэг эрүүл мэндийн байгууллага нь нярайн эрт илрүүлэгт хамрагдсан нярай бүрийн холбогдох мэдээллийг цахим төрөлтийн түүх болон эх хүүхдийн цахим дэвтэрт оруулж, дараагийн шатлалын эмнэлэгт харагдах боломжтойгоор эрүүл мэндийн цахим түүх хөтөлнө;

3.6.5. Нярайн эрт илрүүлгээр мэргэшсэн эмчийн үзлэг, нарийвчилсан оношилгоо, эмчилгээ, хяналтын төлөвлөгөө, шаардлагатай тохиолдолд аль шатлалын эмнэлэгт хандах талаар эх, хүүхдийн цахим дэвтэрт тэмдэглэх, сануулах цахим урилга илгээх, бүртгэх, үзлэг, оношилгоо, шинжилгээний хариу дүгнэлтийг мэдээлэх, эрсдэлтэй тохиолдлыг онош тодруулахаар илгээх, эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах талаар зөвлөмж өгөх үйлчилгээг цахимаар болон биечлэн үзүүлнэ;

3.6.6. Давтан үзлэг шаардлагатай эрт илрүүлгээр өөрчлөлт бүхий нярайг эрт илрүүлгийн төрлөөс хамаарч товлөх ба холбогдох шатлалд товлолт хугацааны дагуу эрүүл мэндийн байгууллага цахим урилга эсхүл утсаар мэдэгдэх, утсанд мэдээлэл илгээх, утсаар дуудах зэргээр зохион байгуулна. Эрт илрүүлгээр эмгэг

онош батлагдсан нярайн оношилгоо, эмчилгээ, хяналтыг алгоритм, зааврын дагуу зохион байгуулж; тэднийг лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагатай холбох үйл ажиллагааг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв хариуцан зохион байгуулна;

3.6.7. Эрт илрүүлгийн төрлөөс хамаарч нярайн давтан илрүүлэг, түүний зохион байгуулалт, хаана, хэрхэн хамрагдах талаарх стандарт мэдээллээр эцэг эхчүүдийг хангаж, шаардлагатай тохиолдолд лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад илгээнэ;

3.6.8. Эрт илрүүлгээр эмгэгтэй нь тогтоогдсон нярайг хяналтад авч, эрт илрүүлгийн төрлөөс хамаарч эмчлэх үйл ажиллагааг эрт илрүүлгийн чадамж бүхий (хүний нөөц, тоног төхөөрөмж, программ хангамж) улсын ба хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, өрх сум, аймаг дүүргийн нярай, хүүхдийн эмч нар хэрэгжүүлж, мэдээллээ тогтмол солилцож ажиллана;

3.6.9. Нярайн цогц эрт илрүүлгийг зохион байгуулах, төрөх үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага нь эрт илрүүлгийн нэгдсэн мэдээллийг батлагдсан маягтын дагуу өдөр бүр нэгтгэн, долоо хоног бүрийн Мягмар гараг бүр Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны албаны “Нярайн эрт илрүүлгийн тандалтын тогтолцоо”-нд утсаар болон цахимаар мэдээлнэ. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны алба нь мэдээллийг нэгтгэн, нэгдсэн дүнг сар бүр Эрүүл мэндийн хөгжлийн төвд мэдээлэх ба долоо хоног, сар, улирал, жилээр эргэн мэдээлнэ. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь бүртгэлтэй жирэмсэн эмэгтэй, эцэг эх, асран хамгаалагч нарт ураг ба шинэ төрөх нярайг эрт илрүүлэгт хамрагдах талаар зөвлөгөө өгч, мэдээллээр хангана;

3.6.10. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны алба нь нярайн эрт илрүүлгийн тандалтын тогтолцооны мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хариу арга хэмжээ төлөвлөхөд бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад дэмжлэг үзүүлж ажиллана.

3.6.11. Мэдээллийн үнэн зөв, хугацаандаа мэдээлсэн байдалд холбогдох тасгийн эрхлэгч, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын алба, эмчилгээ эрхэлсэн дэд захирал нар өдөр бүр хяналт тавьж ажиллана.

Дөрөв. Сургуульд суурилсан эрт илрүүлгийн зохион байгуулалт

4.1. Сургуульд суурилсан эрт илрүүлгийн зохион байгуулалт Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан Сургуульд суурилсан эрт илрүүлгийн журмаар зохицуулагдана.

Тав. Ажлын байран дахь эрт илрүүлгийн зохион байгуулалт

5.1. Ажлын байран дахь эрт илрүүлгийн зохион байгуулалт Эрүүл мэндийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан журмаар Ажилтнуудын эрт илрүүлэг, эрүүл мэндийн үзлэгийн журмаар зохицуулагдана.

Зургаа. Хавдрын эрт илрүүлгийн зохион байгуулалт

6.1. Хүн амын дунд зонхилон тохиолдох байрлалын эрхтэний буюу элэг, улаан хоолой, ходоод, бүдүүн, шулуун гэдэс, уушги, умайн хүзүү, хөхний хорт хавдрын эрт илрүүлгийг хүн амын нас, хүйс, эрсдэлд суурилан зохион байгуулна.

6.2. Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг:

6.2.1. Элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн зорилтот бүлгийн хүн ам нь Гепатитын В, С вирустэй иргэд байна;

6.2.2. Улсын хэмжээнд 18-аас дээш насны, өмнө нь В, С вирусийн шинжилгээ хийлгэж байгаагүй иргэдийг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн байгууллагын төвд В, С вирусийн түргэвчилсэн шинжилгээнд хамруулж, удирдамжийн дагуу эерэг хариу гарсан эмчлүүлэгчийг нийслэл, орон нутгийн (аймаг, дүүрэг) төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын түвшинд вирусийн ачаалал тоолох шинжилгээнд алгоритмын дагуу хамруулна;

6.2.3. Гепатитын В, С вирустэй иргэдийг аймаг, дүүргийн түвшний төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад цусанд АФП тодорхойлох, цусны дэлгэрэнгүй шинжилгээ, биохимийн шинжилгээ (ЭҮА), эхо шинжилгээнд хамруулж, алгоритмын дагуу үнэлнэ;

6.2.4. Гепатитын В,С вирусийн ачаалал өндөртэй хүмүүсийг харьяалалын эмчийн хяналтанд эмчилгээ, оношилгооны зааврын дагуу вирусийн эсрэг эмчилгээнд хамруулна;

6.2.5. Илрүүлгээр элэгний циррозтой илэрсэн иргэдийг 3 сар, элэгний циррозгүй илэрсэн иргэдийг 6 сар тутам алгоритмын дагуу хянана;

6.2.6. Илрүүлгээр элэгний хорт хавдрын сэжигтэй тохиолдол илэрвэл онош тодруулах зорилгоор лавлагаа шатлалын эмнэлэгт цахим дата санд бүртгэж илгээнэ.

6.3. Ходоод, улаан хоолойн хорт хавдрын эрт илрүүлэг:

6.3.1. Улсын хэмжээнд 40-өөс дээш насны иргэдийг 2 жил тутам ходоод, улаан хоолойн хавдрын эрт илрүүлэгт хамруулна;

6.3.2. Аймаг, дүүргийн төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын түвшинд ходоод, улаан хоолойн дурангийн шинжилгээ хийнэ;

6.3.3. Дурангийн шинжилгээгээр хэвийн эсхүл өнгөц үрэвсэлтэй тохиолдолд дотрын эмчийн хяналтад илгээнэ. Дурангийн шинжилгээгээр ходоодны архаг явцтай идэвхтэй үрэвсэл, шарх, шархлаа илэрсэн, эсхүл улаан хоолой, ходоодны сөөргөөт үрэвсэл, барретийн улаан хоолой оношлогдсон, ходоодны их биеийг хамарсан хатингиршил, гэдэсжих метаплази үүссэн тохиолдолд ходоодны дуранг жил тутам хийж, хянана;

6.3.4. Дурангаар ходоодны хорт хавдар сэжиглэж байгаа тохиолдолд эдийн шинжилгээ хийнэ. Эдийн шинжилгээгээр ходоод, улаан хоолойн хорт хавдар батлагдсан тохиолдолд лавлагаа шатлалын эмнэлэгт цахим дата санд бүртгэж илгээнэ.

6.4. Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдрын эрт илрүүлэг:

6.4.1. Улсын хэмжээнд 45-аас дээш насны иргэдийг 2 жил тутам болон гэр бүлийн гишүүдэд ургацаг, хавдрын асуумжтай, бүдүүн гэдэсний шархлаа, кронеор өвдөж байсан өгүүлэмжтэй иргэдийг нас харгалзахгүй үзлэгт хамруулна;

6.4.2. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн байгууллага болон аймаг, дүүргийн төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын түвшинд өтгөнд далд цус илрүүлэх шинжилгээ хийх ба сөрөг хариу гарсан тохиолдолд 2 жил тутам давтан шинжилгээ өгөх буюу эрт илрүүлэгт заасан хугацаанд хамрагдана;

6.4.3. Өтгөнд далд цус илрүүлэх шинжилгээгээр эерэг хариу гарсан иргэдэд бүдүүн, шулуун гэдэсний дуран хийж, дурангаар өөрчлөлтгүй гарсан тохиолдолд 2 жил тутам буюу товлосон хугацаанд эрт илрүүлэгт хамрагдана;

6.4.4. Хоёр удаа өтгөнд далд цус илрүүлэх шинжилгээ хийхэд сөрөг хариу гарсан тохиолдолд бүдүүн, шулуун гэдэсний дурангийн шинжилгээ хийнэ;

6.4.5. Дурангаар өөрчлөлттэй гарсан эмчлүүлэгчийг эрсдлийн зэргээр заавар, алгоритмын дагуу ангилж, бүдүүн гэдэсний хорт хавдар батлагдвал лавлагаа шатлалын төр, хувийн хэвшлийн эмнэлэгт цахим дата санд бүртгэж илгээнэ.

6.5. Уушгины хорт хавдрын эрт илрүүлэг:

6.5.1. Улсын хэмжээнд 50-аас дээш насны иргэдийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагын түвшинд дуудаж, бүртгэх ба асуумжаар 15-аас дээш жил тамхи татсан иргэдийг аймаг, дүүргийн түвшний төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад бага тунт КТГ хийж, алгоритмын дагуу үнэлнэ;

6.5.2. Бага тунт КТГ хийхэд Lung RADS 1-2 оноо үнэлэгдсэн эмчлүүлэгчдэд жил тутам бага тунт КТГ шинжилгээг давтана. Lung RADS 3 оноо үнэлэгдсэн эмчлүүлэгчид 3-6 сар тутам бага тунт КТГ давтан хийнэ.

6.5.3. Lung RADS 4 оноо үнэлэгдсэн эмчлүүлэгчид нэмэлтээр цээжний тодосгогчтой КТГ, эдийн шинжилгээ хийж, уушгины хорт хавдар батлагдсан тохиолдолд лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад цахим дата санд бүртгэж илгээнэ.

6.6. Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг:

6.6.1. Улсын хэмжээнд 27 нас, 45-аас дээш насны эмэгтэйд 3 жил тутам 63 нас хүртэл эсийн шинжилгээ, 30 болон 40 насны эмэгтэйд ХПВ шинжилгээг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн байгууллага болон аймаг, дүүргийн төр, хувийн хэвшлийн түвшинд хийж, алгоритмын дагуу үнэлнэ;

6.6.2. Умайн хүзүүний хорт хавдар оношлогдвол лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад цахим дата санд бүртгэж илгээнэ.

6.7. Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг:

6.7.1. Улсын хэмжээнд 40-70 насны эмэгтэйд 2 жилийн давтамжтай аймаг, дүүргийн төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын түвшинд хөхний хэт авиан шинжилгээ хийнэ;

6.7.2. Хэт авиан шинжилгээгээр BIRADS 1 үнэлэгдвэл товлотт насны урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдана. BIRADS 2 үнэлэгдвэл аймаг, дүүргийн мэс заслын эмчийн хяналтад орж, 1 жилийн дараа хөхний хэт авиан шинжилгээг давтана;

6.7.3. BIRADS 0, BIRADS 3, BIRADS 4, BIRADS 5 үнэлэгдвэл маммографийн шинжилгээг хийнэ;

6.7.4. Маммографийн шинжилгээгээр BIRADS 0 үнэлэгдвэл хөхний олон мэргэжилтний хамтарсан багийн зөвлөгөөнөөр шийднэ, BIRADS 3 үнэлэгдвэл өмнөх шинжилгээтэй харьцуулан богино хугацааны буюу 6 сарын хяналтад авна, BIRADS 4, BIRADS 5 үнэлэгдвэл багажийн шинжилгээний хяналтад эс, эдийн шинжилгээ хийх ба BIRADS 6 үнэлэгдсэн тохиолдолд лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад цахим дата санд бүртгэж илгээнэ.

6.8. Хавдрын эрт илрүүлэг эрүүл мэндийн байгууллагаас зохион байгуулах:

6.8.1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь бүртгэлтэй хүн амыг тухайн жилд эрт илрүүлэгт хамруулах судалгаа /Овог нэр, регистрийн дугаар, хүйс, эрүүл мэндийн бүлэг гэх мэт/-г жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт цахим дата санд бүртгэн хүргүүлнэ.

6.8.2. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь бүртгэлтэй хүн амыг эрт илрүүлэгт дуудах, бүртгэх, хянах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

6.8.3. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь зонхилох байрлалын хорт хавдрын эрт илрүүлгийн алгоритмын үйл ажиллагааг дагуу зохион байгуулна.

6.8.4. Аймаг, дүүргийн түвшний төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага нь зонхилох байрлалын хорт хавдрын эрт илрүүлгийг алгоритмын дагуу зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд телемедицин, дүрс оношилгооны хариу уншилтын төвтэй холбогдон зөвлөгөө авч болно.

6.8.5. Аймгийн эрүүл мэндийн байгууллага нь эмгэг судлалын шинжилгээний сорьцыг слайд сканер ашиглан Эмгэг судлалын үндэсний төвд цахим дата санд бүртгэн хүргүүлнэ.

6.8.6. Төр, хувийн хэвшлийн лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага эрт илрүүлгээр өөрчлөлттэй гарсан иргэдийг эмчилж, хяналтад авна.

6.8.7. Зонхилох байрлалын хорт хавдрын эрт илрүүлгийн мэдээллийг цахимжуулж, эмнэлгийн мэдээллийн цахим сангийн нэгдсэн дата санд мэдээллийг оруулж хадгална.

6.8.8. Хавдар судлалын үндэсний төв нь хавдрын эрт илрүүлгийн мэдээллийг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, цаашид сайжруулах бодлогын санал, зөвлөмж гаргана.

Долоо. Эрт илрүүлгийн тусламж үйлчилгээг улсын хэмжээнд зохион байгуулахад эрүүл мэндийн байгууллагын чиг үүрэг

7.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хүлээнэ. Үүнд:

7.1.1. Эрт илрүүлэгтэй холбоотой эмнэлзүйн заавар шаардлагатай тохиолдолд олон улсын туршлага, нотолгоо, судалгаа, мэргэжлийн тэргүүлэх байгууллага, мэргэжлийн салбар зөвлөлийн саналыг үндэслэн судалж, тогтмол шинэчлэх;

7.1.2. Эрт илрүүлгийн үйл ажиллагааны зохион байгуулалт, үр дүн, зардлын үр ашиг, эрүүл мэндийн салбарт үзүүлэх үр нөлөөг үнэлэх, судлах, хэрэгжилтэд хяналт тавих;

7.1.3. Эрт илрүүлгийн цахим системийг эрүүл мэндийн салбарын бусад цахим платформуудтай холбох;

7.1.4. Эрт илрүүлгийн өгөгдөл, мэдээлэлд нэмэлт болон нарийвчилсан боловсруулалт, дүн шинжилгээг хийж, өвчлөл, түүний эрсдэлт хүчин зүйлсийн байдал, чиг хандлагыг тодорхойлон дүгнэлт, зөвлөмж гаргах хөндлөнгийн судалгааны багийг удирдан ажиллуулах.

7.2. Эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллага дараах чиг үүргийг хүлээнэ. Үүнд:

7.2.1. Эрт илрүүлгийн үйл ажиллагааг үндсэн тусламж, үйлчилгээний чиглэлээр энэ журмын 1.5-д заасан эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

7.2.2. Эрт илрүүлгийн тусламж, үйлчилгээний эмнэлзүйн зааврыг ашиглан сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалтад эрүүл мэндийн ажилтанг хамруулах ажлыг зохион байгуулах;

7.2.3. Онош тодруулахаар илгээсэн тохиолдлыг хүлээн авч, оношийг баталгаажуулах, эмчлэх, шаардлагатай тохиолдолд мэргэшсэн эмчийн шууд хяналтад авах, эргэн мэдээлэх;

7.2.4. Эрүүл мэндийн байгууллагын дэргэдэх Эрүүл мэндийг дэмжих төв, амбулаториор дамжуулан эрт илрүүлгийг зохион байгуулах;

7.2.5. Явуулын хэлбэрээр эрт илрүүлэг зохион байгуулах баг гарган тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

7.3. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв дараах чиг үүргийг хүлээнэ. Үүнд:

7.3.1. Эрүүл мэндийн анхдагч болон завсрын эрсдэлт хүчин зүйлийг үнэлэхэд эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, сургалт зохион байгуулах;

7.3.2. Эрт илрүүлгийн тусламж, үйлчилгээний эмнэлзүйн заавар, гарын авлага, сургалтын хөтөлбөрт санал өгөх;

7.3.3. Эрт илрүүлгийн товлолт насны бүлгээр иргэнд зориулсан гарын авлага, сургалт, сурталчилгааны материалыг боловсруулж, түгээх;

7.3.4. Эрт илрүүлгийн товлолын талаарх мэдээллийг сурталчлах нэгдсэн загварыг гаргаж, эрүүл мэндийн байгууллагуудад түгээх, байгууллагын цахим хуудсанд байршуулах;

7.3.5. Эрт илрүүлгийн ач холбогдлыг таниулж, товлолын дагуу хамрагдахыг хүн амд уриалсан мэдээллийг шинжлэх ухааны нотолгоонд түшиглэн хүн бүрд ойлгомжтой байхаар боловсруулж, мэдээллийн бүх төрлийн сувгаар хүртээмжтэй түгээх;

7.3.6. Холбогдох байгууллагуудтай хамтарч эрт илрүүлгийн тайлан, мэдээг, улирал, хагас, бүтэн жилээр нэгтгэж, дүн шинжилгээ хийж бодлого, шийдвэр гаргагчдыг нотолгоонд суурилсан мэдээллээр хангах, санал зөвлөмж гаргах.

7.4. Эрүүл мэндийн хөгжлийн төв дараах чиг үүргийг хүлээнэ. Үүнд:

7.4.1. Эрт илрүүлгийг зохион байгуулах эрүүл мэндийн ажилтанг чадавхжуулах богино хугацааны сургалтыг улсын хэмжээнд үе шаттай зохион байгуулах;

7.4.2. эрүүл мэндийн ажилтанг чадавхжуулах сургалтуудыг тасралтгүй зохион байгуулах;

7.4.3. Эмнэлзүйн заавар, сургалтад ашиглах эмнэлзүйн заавар, сургалтын модуль, гарын авлагын нэгдсэн санг үүсгэн, байгууллагын цахим хуудсанд байршуулах.

7.4.4. Эрт илрүүлэгт ашиглах эрүүл мэндийн анхан шатны бүртгэлийн маягтыг шинэчлэх, давхардлыг арилгах;

7.4.5. Эрт илрүүлгийн тоо мэдээг цуглуулж, өдөр тутмын чанарын хяналт тавьж, нэгтгэн долоо хоног бүрийн пүрэв гарагт мэдээллийг төрийн захиргааны төв байгууллагад цахим дата сангаар дамжуулан мэдээлэх;

7.4.6. Эрт илрүүлгийн урилга илгээх, дуудах-эргэн дуудах, эрүүл мэндийн лавлагаа гаргах нэгдсэн цахим программ хангамжийг хариуцан, шуурхай тасралтгүй байдлыг ханган ажиллах;

7.4.7. Цахим системийн сургалтыг зохион байгуулж, тасралтгүй, тогтмол хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах;

7.4.8. Эрт илрүүлгийн үр дүнгийн талаарх мэдээллийг холбогдох байгууллагуудтай хамтарч улсын хэмжээнд сар бүр нэгтгэн нээлттэй мэдээлэх.

7.5. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар дараах чиг үүргийг хүлээнэ. Үүнд:

7.5.1. Эрт илрүүлэгт шаардагдах лабораторийн урвалж бодис, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийн судалгааг гаргаж, тэдгээрийн хангамж, ашиглалт, чанар аюулгүй байдалд хяналт, зохицуулалт хийн, эрүүл мэндийн байгууллагуудыг мэдээллээр хангах;

7.5.2. Шаардлагатай тохиолдолд эрт илрүүлэгт ашиглагдах эмнэлгийн хэрэгслийн нэгдсэн худалдан авалт зохион байгуулах, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;

7.5.3. Эрт илрүүлэгт шаардагдах эмнэлгийн хэрэгслийн зах зээл дэх үнийн судалгааг жил бүр гаргаж, зохиомол хөөрөгдөлт бий болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, тогтмол хянах.

7.6. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар дараах чиг үүргийг хүлээнэ. Үүнд:

7.6.1. Эрт илрүүлэгт шаардлагатай санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх, хяналт тавих журмыг боловсруулж, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөр батлуулах;

7.6.2. Эрүүл мэндийн байгууллагын шатлал тус бүрээр санхүүжилтийг тооцож, эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөрийг санхүүжүүлж буй бусад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй давхардуулалгүй сангийн үр ашгийг нэмэгдүүлэх байдлаар төсвийн төслийг боловсруулж жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл, тухайн оны төсвийн тухай хуульд тусгахаар холбогдох байгууллагуудад хүргүүлж, батлуулах;

7.6.3. Эрт илрүүлгийг зохион байгуулах эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллах;

7.6.4. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран олон нийтэд сурталчлах, халдварт болон халдварт бус өвчлөлийн эрсдэлт хүчин зүйлсийг бууруулахад эрт илрүүлгийн ач холбогдлын талаар эрүүл мэндийн байгууллага болон даатгуулагчдад зориулсан зөвлөгөө, мэдээллийн үйл ажиллагаа зохион байгуулах;

7.6.5. Эрт илрүүлгийн санхүүжилтийн талаарх үр дүн, үр ашиг, үр нөлөөний талаарх судалгаа, тооцооллыг хийж, хяналт тавих.

7.7. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар дараах чиг үүрэг хүлээнэ. Үүнд:

7.7.1. Эрт илрүүлгийг зохион байгуулахад харьяалах нутаг дэвсгэрийн иргэдийг хамруулах үйл ажиллагааг мэргэжлийн арга зүй, нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллах;

7.7.2. Эрт илрүүлгийг үндсэн тусламж, үйлчилгээний хүртээмж, оношилгоо эмчилгээний чанар, аюулгүй байдлыг алдагдуулахгүйгээр зохион байгуулах;

7.7.3. Эрт илрүүлгийн мэдээ, мэдээллийн шуурхай, үнэн зөв байдлыг хангаж, тайланг хүлээн авч нэгтгэн, сар бүрийн 20-ны дотор Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргэх;

7.7.4. Эрт илрүүлэгт шаардагдах лабораторийн урвалж бодис, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл болон бүртгэлийн маягт, цахим программ, хүний нөөцийн хангамж, сургалтын хэрэгцээнд үнэлгээ хийж, шаардлагатай зардлыг тооцон орон нутгийн болон эрүүл мэндийн салбарын жил бүрийн төсвийн төсөлд тусгах саналыг боловсруулж эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;

7.7.5. Орон нутгийн иргэдийн эрт илрүүлгийн тайлан, мэдээг нэгтгэж, дүн шинжилгээ хийж холбогдох арга хэмжээ авах, удирдлагыг мэдээллээр хангах;

7.7.6. Журмын 1.6-д заасан эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулах.

7.8. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага дараах чиг үүрэг хүлээнэ. Үүнд:

7.8.1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь бүртгэлтэй хүн амыг тухайн жилд эрт илрүүлэгт хамруулах судалгааг гаргаж, эрт илрүүлэгт бэлтгэх;

7.8.2. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь бүртгэлтэй хүн амыг эрт илрүүлэгт дуудах, бүртгэх, хянах үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

7.8.3. Харьяалах нутаг дэвсгэрийн зорилтот бүлгийн хүн амыг эрт илрүүлгийн үзлэг хамруулах үйл ажиллагааг бие даан болон холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

7.8.4. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь 40-өөс дээш насны иргэдэд ЗСӨ-ний эрсдэлийн үнэлгээ, Чихрийн шижингийн эрсдэлийн үнэлгээг хийнэ;

7.8.5. Эрт илрүүлгийг үндсэн тусламж, үйлчилгээний хүртээмж, оношилгоо эмчилгээний чанар, аюулгүй байдлыг алдагдуулахгүйгээр зохион байгуулах;

7.8.6. Эрт илрүүлгийн үр дүнд эмгэг илэрсэн тохиолдолд Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хяналтад байх шаардлагатай хүн амыг хяналтад авч, шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэх;

7.8.7. Эрт илрүүлгийн үр дүнд үндэслэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, мэдээлэл, сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг харьяалах нутаг дэвсгэрийн хүрээнд зохион байгуулах.

Найм. Эрт илрүүлгийн талаарх мэдээллийн ил тод байдал, эрт илрүүлгийн үр дүнг үнэлэх

8.1. Эрт илрүүлэгт товллын дагуу хамрагдах талаар иргэнд сануулж цаасан болон цахим урилга илгээх, дуудах-эргэн дуудах, бүртгэх, үзлэг шинжилгээний хариу дүгнэлтийг мэдээлэх, эрсдэлтэй тохиолдлыг онош тодруулахаар илгээх, эрүүл мэндийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн зөвлөмжийг өгөх үйлчилгээ цахимаар хийнэ.

8.2. Иргэн эрт илрүүлэгт хэрхэн хамрагдах заавар зөвлөгөө, дараалал, алгоритм, эрт илрүүлгийн хариу дүгнэлт, дараагийн шатлалд онош баталгаажуулах талаар эрүүл мэндийн байгууллагын мэдээллийг цахим, үүрэн утас, хэвлэмэл байдлаар авах боломжийг бүрдүүлнэ.

8.3. Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллага нь эрт илрүүлэгт хамрагдах өвчин, эмгэгийн жагсаалт, товлал, эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх журмын талаар иргэдийг нээлттэй, ил тод мэдээллээр хангаж ажиллана.

8.4. Эрүүл мэндийн хөгжлийн төв урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийн үр дүнгийн талаар дараах мэдээллийг улсын хэмжээнд сар бүр нэгтгэн цахим хуудсаар нээлттэй мэдээлнэ. Үүнд:

8.4.1. Эрт илрүүлэгт хамрагдсан хүний тоо, зорилтот бүлэг тус бүрээр;

8.4.2. Эрт илрүүлэгт хамрагдсан хүний эрсдэлийн үнэлгээний дүн, зорилтот бүлэг тус бүрээр;

8.4.3. Онош тодруулахаар илгээсэн хүний тоо, зорилтот бүлэг тус бүрээр;

8.4.4. Илрүүлсэн өвчин эмгэгийн тохиолдлын тоо, зорилтот бүлэг тус бүрээр;

8.4.5. Илрүүлсэн өвчин эмгэгийг, эрсдэлтэй хамааруулсан дүн, зорилтот бүлэг тус бүрээр.

8.5. Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан эрт илрүүлгийн арга хэмжээний үр дүнг жил тутамд, зардал үр ашгийн дүн шинжилгээг 5 жил тутамд тооцож, танилцуулна.

8.6. Эрт илрүүлгийн үр дүнгийн үнэлгээ, зардлын үр ашгийн дүн шинжилгээнд тулгуурлан энэхүү журмыг тогтмол шинэчилнэ.

Ес. Эрт илрүүлгийн тусламж, үйлчилгээний бүртгэл мэдээлэл, Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээний сангийн үйл ажиллагааны чиг үүрэг

9.1. Эрт илрүүлгийн тусламж үйлчилгээний анхдагч бүртгэлийг цахим системд бүртгэхдээ Эрүүл мэндийн сайдын А/611 дугаар тушаалын хавсралтыг дагаж мөрдөнө.

9.2. Эмнэлгийн байгууллагад ашиглаж буй мэдээллийн систем нь Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээний сантай холбогдож өгөгдөл солилцдог байна.

9.3. Эрт илрүүлгийн тусламж үйлчилгээний өгөгдлийг Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээний санд /Эрүүл мэндийн хөгжлийн төв/ цуглуулна.

9.4. Эрт илрүүлгийн тусламж үйлчилгээний хүрээнд цугласан өгөгдлийг тандалтын нэгжүүд болон оролцогч талуудад Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээний сангаар /Эрүүл мэндийн хөгжлийн төв/ дамжуулан нэгдсэн зохион байгуулалтаар олгож дүн шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглуулна.

9.5. Эрт илрүүлгийн тусламж үйлчилгээний хүрээнд цугласан өгөгдөлд үндэслэж Эргэн дуудах, эргэх холбоо бүхий тогтолцоог Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээний сангаар /Эрүүл мэндийн хөгжлийн төв/ дамжуулан И-Монгол гар утасны аппликейшн, гар утасны мессеж болон харьяа хороо, сумын анхан шатны эмнэлгүүдэд өгөгдөл солилцож мэдээлнэ.

--o0o--

Эрүүл мэндийн сайдын 2025 оны . . . дугаар
сарын . . . -ны өдрийн дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

**НАС, ХҮЙС, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРСДЭЛД СУУРИЛСАН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ҮЗЛЭГТ ЗОРИЛТОТ
БҮЛГИЙН ХҮН АМЫГ ХАМРУУЛАХ ТОВЛОЛ, ДАВТАМЖ**

[illegible]


5		Түнхний эхо		цагийн дотор											
6		Хатаасан цусны толбо													
1	Дутуу нярайн эрт илрүүлэг	Пульсоксиметр		Төрснөөс хойш 28 хоногт											
2		Сонсгол													
4		Торлогийн дуран													
5		Түнх													
6		Хатаасан цусны толбо													
7		Зулайн эхо													
1	Сургуульд суурилсан эрт илрүүлэг	Амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг			Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан тушаалаар батлагдсан журмын дагуу										
2		Хараа шалгах													
3		Сонсгол шалгах													
4		Зүрхний цахилгаан бичлэг													
5		Бусад													
1	Хорт хавдрын эрт илрүүлэг	Умайн хүзүүний хорт хавдар	ХПВ илрүүлэх сорил								30, 40 настай эмэгтэй				
2			Эсийн шинжилгээ ПАП сорил (эмэгтэй)							Эмэгтэй				Эмэгтэй, 3 жилд 1 удаа	
3			Кольпоскопи							Алгоритмын дагуу				Алгоритмын дагуу	
1		Элэгний хорт хавдар	Гепатит В, С илрүүлэх хурдавчилсан сорил										Өмнө нь шинжилгээ хийлгэж байгаагүй болон өмнө нь хариу сөрөг гарсан тохиолдолд жил бүр		
2			Гепатит В, С вирусийн ачаалал тоолох шинжилгээ										Алгоритмын дагуу		
3			Цусанд АФП тодорхойлох, ЦДШ, Биохими (ЭҮА), ЭХО										Алгоритмын дагуу		

1		Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдар	Өтгөнд далд цус илрүүлэх										Алгоримтын дагуу шалгуур хангасан иргэд 2 жилд 1 удаа	2 жилд 1 удаа		
2			Бүдүүн, шулуун гэдэсний дурангийн шинжилгээ										Алгоримтын дагуу			
3			Эдийн шинжилгээ										Алгоримтын дагуу			
1		Улаан хоолой, ходоодны хорт хавдар	Дурангийн шинжилгээ											2 жил 1 удаа		
2			Эдийн шинжилгээ										Алгоримтын дагуу			
1		Уушгины хорт хавдар	Бага тунт КТГ													15-аас дээш жил тамхи татсан бол 1 удаа
2			Цээжний тодосгогчтой КТГ												Алгоримтын дагуу	
3			Эдийн шинжилгээ												Алгоримтын дагуу	
1		Хөхний хорт хавдар	Хөхний хэт авиан шинжилгээ											40-70 насны эмэгтэй, 2 жилд 1 удаа		
2			Маммографи											Алгоримтын дагуу		
3			Эс, эдийн шинжилгээ											Алгоримтын дагуу		
1		Ажлын байран дахь эрт илрүүлэг	Ажилтнуудын эрт илрүүлгийн багц										Эрүүл мэндийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар батлагдсан журмын дагуу			
2			Мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн эрт илрүүлгийн багц													
1	Эмчийн дүгнэлт, зөвлөмж, хяналт															

**НАС, ХҮЙС, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРСДЭЛД СУУРИЛСАН ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ХҮН АМД
ЧИГЛЭСЭН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ҮЗЛЭГИЙН ЗУРАГЛАЛ**

1. Ургийн хромосомын гажгийн эрт илрүүлгийн зураглал
2. Нярайн зүрхний төрөлхийн гажгийн эрт илрүүлгийн зураглал
3. Нярайн төрөлхийн дүлийрэлт, сонсгол бууралтын эрт илрүүлгийн зураглал
4. Нярайн түнхний дутуу хөгжлийн эрт илрүүлгийн зураглал
5. Нярайн бодисын солилцооны эмгэгийн эрт илрүүлгийн зураглал
6. Гүйцэд нярайн нүдний эмгэгийн эрт илрүүлгийн зураглал
7. Дутуу нярайн ретинопатийн эрт илрүүлгийн зураглал
8. Дутуу нярайн мэдрэлийн эмгэгийн эрт илрүүлгийн зураглал
9. Элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн зураглал
10. Ходоод, улаан хоолойн хорт хавдрын эрт илрүүлгийн зураглал
11. Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдрын эрт илрүүлгийн зураглал
12. Уушгины хорт хавдрын эрт илрүүлгийн зураглал
13. Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн зураглал
14. Хөхний хорт хавдрын эрт илрүүлгийн зураглал


1. УРГИЙН ХРОМОСОМЫН ГАЖГИЙН ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ЗУРАГЛАЛ




2. НЯРАЙН ЗҮРХНИЙ ТӨРӨЛХИЙН ГАЖГИЙН ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ЗУРАГЛАЛ




3. НЯРАЙН ТӨРӨЛХИЙН ДҮЛИЙРЭЛТ, СОНСГОЛ БУУРАЛТЫН ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ЗУРАГЛАЛ



4. НЯРАЙН ТҮНХНИЙ ДУТУУ ХӨГЖЛИЙН ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ЗУРАГЛАЛ




5. НЯРАЙН БОДИСЫН СОЛИЛЦООНЫ ЭМГЭГИЙН ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ЗУРАГЛАЛ




6. ГҮЙЦЭД НЯРАЙН НҮДНИЙ ЭМГЭГИЙН ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ЗУРАГЛАЛ




7. ДУТУУ НЯРАЙН РЕТИНОПАТИЙН ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ЗУРАГЛАЛ




8. ДУТУУ НЯРАЙН МЭДРЭЛИЙН ЭМГЭГИЙН ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ЗУРАГЛАЛ







10. ХОДООД, УЛААН ХООЛОЙН ХОРТ ХАВДРЫН ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ЗУРАГЛАЛ



11. БУДУУН, ШУЛУУН ГЭДЭСНИЙ ХОРТ ХАВДРЫН ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ЗУРАГЛАЛ





13. УМАЙН ХҮЗҮҮНИЙ ХОРТ ХАВДРЫН ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ЗУРАГЛАЛ

